




МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ СУРГУУЛЬ

ББК
72
О-29

VOL. 184 (5)
2002 №1

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА WORLD AFFAIRS



Улаанбаатар хот

Тус сэтгүүл нь анх 1996 оноос "Алтан аргамж" нэрээр, 2002 оноос "Олон улсын харилцаа" нэрээр гарч байна.

The journal has been published since 1996 as "Altan argamj" and since 2002 as "World Affairs".

Сэтгүүлийн зөвлөл:

Editorial Board:

Эрхлэгч:

Н.Алтанцэцэг (проф.доктор Ph.D)

Editor in Chief:

N.Altantsetseg (Prof.Ph.D)

Нарийн бичгийн дарга:

Д.Тунгалаг (дэд.проф.доктор Ph.D)

Assistant Editor:

D.Tungalag (Prof.Ph.D)

Гишүүд:

Ж.Баясах (тэр.проф.доктор Ph.D)
Ж.Бор (проф.доктор Ph.D)
Ц.Гүрбадам (проф.доктор Sc.D)
Л.Даваадэлгэр Ахлах багш
С.Отгонбаатар (дэд проф.доктор Ph.D)
Д.Цолмон (тэр.проф.доктор Ph.D)

Members:

J.Bayasakh (Prof.Ph.D)
J. Borr (Prof.Ph.D)
Ts.Gurbadam (Prof.Sc.D)
L.Davaadelger Senior Lecturer
S.Otgonbaatar (Prof.Ph.D)
D.Tsolmon (Prof.Ph.D)

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

С.Энхцэцэг

Typist:

S.Enkhtsetseg

Сэтгүүлийн хаяг:

МУИС-ийн Олон улсын
харилцааны сургууль
Шуудангийн хайрцаг – 46 а
Улаанбаатар, Монгол улс
Утас: 310091; 318640; 318121
Факс: (976-11) 311809
E – mail: sfs@num.edu.mn

Editorial Address:

School of Foreign Service
Mongolian National University
P.O.Box – 46 a
Ulaanbaatar, Mongolia
Tel: 310091; 318640; 318121
Fax: (976-11) 311809
E – mail: sfs@num.edu.mn



Тэргүүн өгүүлэл

Л.Эрдэнэчулуун	Хөгжлийн төлөө хамтын ажиллагааны 40 жил.....	5
----------------	---	---

I. Олон улсын харилцааны түүх

1. Н.Алтанцэцэг	Төв Азийн нүүдэлчид ба Хятадын харилцааны судалгаанд Америкийн эрдэмтэн Оуэн Латтимор, Моррис Россabi нарын оруулсан хувь нэмэр, гол үзэл баримтлал.....	13
2. Н.Алтанцэцэг	Америк дахь Монголын талаархи сүүлийн үеийн судалгааны зохиолуудын тойм	21
3. Д.Уламбаяр	Монгол – Францын харилцааны ойрхи үеийн түүхэн тэмдэглэл	28
4. Д.Уламбаяр	Монголын тусгаар тогтнолын талаархи профессор Ж.Цэвээний бодрол.....	59
5. Н.Мөнхцэцэг	XX зууны эхэн үеийн Монголын улс төрийн гадаад харилцааны түүхэнд Эрдэнэ Жинон ван Ширнэндамдингийн оруулсан хувь нэмэр	68

II. Геополитик, олон улсын эрх зүй

1. <u>Х.Олзвой</u>	Японы геополитик дахь Монгол	84
2. <u>Х.Олзвой</u>	Монгол – АНУ-ын харилцаа, Монголын аюулгүй байдлын зарим асуудал.....	88
3. Д.Баярхүү	БНЭУ-ын гадаад бодлогын хувьсал, Их гүрнүүдийн геополитикийн сонирхол	97
4. Stewart Fenwick	Adopting the 1951 UN Refugee Convention.....	109
5. З.Энхтайван	Олон улсын эрх зүйн түүхийн үечлэлийн асуудалд.....	112
6. Л.Түвшинцэнгэл	Дүрвэгсдийн асуудал Монгол улсын үндэсний аюулгүй байдалд холбогдох нь.....	121

III. Олон Улсын Эдийн Засгийн Харилцаа

1. С.Отгонбаатар	Дэлхийн эдийн засаг дахь интеграцийн үйл явц	126
2. С.Отгонбаатар	Зүүн Хойд Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны үйл явц, түүнд Монгол улс оролцох нь	134
3. Д.Тунгалаг	Олон улсын статистик үүсч хөгжсөн үндсэн үе шатууд, глобал статистик системийн өнөөгийн байдал.....	144
4. Д.Мөнхтуяа	Шилжилтийн үеийн Монголын эдийн засгийн хөгжлийн зарим онцлог	151

IV. Дипломатчдын дурсамж

1. Ц.Гүрбадам	Түүхт хүмүүсийн нүгэл буяныг түүх л дэнсэлнэ.....	157
2. <u>Х.Олзвой</u>	Ж.Бейкерийн айлчлал хийгээд "гурав дахь түнш"-ийн асуудалд	166

CONTENTS

Leading article

- Erdenechuluun L 40 year's Cooperation for Development5

I. History of International Relations

1. Altantsetseg N Research of Prof. O.Lattimore and M. Rossabi on relations between Central Asian Nomads and China.....13
- ② Altantsetseg N Current Studies on Mongolia in the USA.21
3. Ulambayar D Prof. Cyben Zamcaranovic Zamcarano's Concept Regarding the Mongolian Sovereignty28
4. Ulambayar D Recent Historical Notes on Mongolian – French Relations59
5. Munkhtsetseg N Duke Shirnendamdin and his Role in History of Mongolian Foreign Relations68

II. Geopolitics and International Law

1. Olzvoy Kh Mongolia in Japanese Geopolitics84
- ② Olzvoy Kh Mongolia – USA Relations and Some Aspects of Mongolian Security88
3. Bayarkhuu D Indian Foreign Policy Evolution and Geopolitical Interests of Major Powers in India 97
4. Stewart Fenwick Adopting the 1951 UN Refugee Convention.....109
5. Enkhtaiwan Z To Issues of International Law History Chronology112
6. Tuvshintengel L Refugee Issues and Mongolian National Security.....121

III. International Economic Relations

1. Otgonbaatar S Integration Process in the World Economy126
2. Otgonbaatar S Northeast Asian Economic Cooperation and Mongolia..... 134
3. Tungalag D The Evolution, development stages of international statistics, present day system of global statistics144
4. Munkhtuya D Features of Mongolian Economic Development in Transitional Period 151

IV. Diplomats Memoirs

1. Gurbadam Ts Judgement of the Historical Persons will be done by the History. 157
- ② Olzvoy Kh J. Baker's Visit to Mongolia and his remark on the "Third partner" 166

ТЭРГҮҮН ӨГҮҮЛЭЛ

“ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ 40 ЖИЛ”

**“Монгол улс, НҮБ-ын хамтын ажиллагаа 40 жилд:
Мянганы тунхаглалын хэрэгжилт” сэдэвт
бага хуралд ГХ-ийн сайд Л.Эрдэнэчулууны
тавьсан илтгэл**

**2001 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр,
Улаанбаатар хот**


*Эрхэм хүндэт Ерөнхий сайд аа,
Эрхэм хүндэт ноён В.Ф.Петровский,
Эрхэм хатагтай С.Менон,
Хатагтай, ноёд оо,*

«Монгол Улс, НҮБ-ын хамтын ажиллагаа 40 жилд: Мянганы Тунхаглалын хэрэгжилт» сэдэвт бага хуралд хүрэлцэн ирсэн та бүхний амар амгаланг айлтгаж, манай хамтын ажиллагааны 40 жилийн ажлыг нэгтгэн дүгнэж, цаашдын зорилтуудыг тодорхойлоход үнэтэй хувь нэмрээ оруулна гэж найдаж байгаагаа юуны өмнө хэлэхийг хүсч байна. Ялангуяа, 40 жилийн тэртээ улс орноо олон улсын хамтын нийгэмлэгийн гишүүн болгох үйлсэд гар бие оролцож явсан, өнгөрсөн хугацаанд НҮБ дахь Монгол Улсын байр суурийг бэхжүүлэхэд хүчин зүтгэж байсан манай ахмад дипломатчид энд хүрэлцэн ирсэн нь манай бага хурлын утга агуулгыг улам баялаг, хүндэтгэлтэй болгож байгаад миний бие баяртай байна.

Хатагтай, ноёд оо,

Ярих сэдвийн үндсэн хэсэгтээ орохын өмнө та бүхэнд ноён В. Ф. Петровскийг товч танилцуулахыг хүсч байна. Ерөнхий захирал ноён В. Ф. Петровский бол миний эртний бөгөөд дотны найз, хуучин ЗХУ-ын Гадаад явдлын яамны орлогч сайд, ОУБ-ын газрын дарга байхдаа олон улсын асуудлаар НҮБ-ын хүрээнд бидэнтэй ойр дотно хамтран ажиллаж байсан туршлагатай, мэргэжлийн ур чадвар бүхий нэртэй дипломатч билээ. Одоо ч Женев дэх НҮБ-ын салбарыг удирддагийн хувьд Монгол-НҮБ-ын хамтын ажиллагааг улам өргөжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулах нөлөө бүхий НҮБ-ын өндөр албан тушаалтан. Тэрбээр энэхүү арга хэмжээнд ЕНБД-ын бие төлөөлөгчөөр хүрэлцэн ирсэнд Монгол Улсын Засгийн газар өндөр ач холбогдол өгч байгааг тэмдэглэхийг хүсч байна.

НҮБ-ын гишүүн байсан 40 жилийн хугацаанд Монгол Улсын хийж гүйцэтгэсэн ажил, үр дүнг өндөр үнэлж, тус бага хуралд мэндчилгээ



ирүүлсэн Ерөнхий нарийн бичгийн дарга ноён Кофи Аннанд бидний гүн талархлыг уламжилж өгөхийг ноён В. Ф. Петровский Танаас мөн хүсье.

Хатагтай, ноёд оо,

Монгол Улс XX зууны түүхэндээ олсон томоохон ололтын нэг нь 1961 онд НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болсон явдал байлаа. Үе үеийн монголчуудын уйгагүй тэмцлийн ачаар 1911 онд харийн колончлолоос ангижирч, 1921 онд тусгаар тогтнолоо эгүүлэн олсноос хойш дэлхийн тавцан дээр өөрийн байр сууриа эзлэх хариуцлагатай зорилт бидний өмнө тулгарсан билээ.

Олон зуун жилийн турш бусдын хараат байж, бараг мартагдсан Монгол орны хувьд энэ бол амар ажил байгаагүй. Бидний олон жилийн зүтгэл, хамтын хүч чармайлтын үр дүнд үзэл суртлын сэргөлдөөн, хүйтэн дайны хатуу уур амьсгалыг даван туулж, манай орон олон улсын хамтын нийгэмлэг дэх хууль ёсны байр сууриа эзэлсэн юм.

Тухайн үед НҮБ-ын гишүүн байсан 100 орчим улс орон бүгд Монгол Улсын төлөө саналаа өгсөн нь манай улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн хэрэг байлаа. Тэр үед ердөө л 19 улстай дипломат харилцаатай байсан Монгол Улсын хувьд энэ бол улс төр, дипломатын үнэлж баршгүй том амжилт, манай улсын тусгаар тогтнолын улс төрийн чухал баталгаа мөн.

Монгол Улсын өмнө ийнхүү олон улсын байр сууриа бэхжүүлэх, гадаад бодлогын үйл ажиллагаагаа өргөжүүлэн идэвхжүүлэх олон талын ач холбогдолтой боломж нээгдэв. Тэр цагаас хойш Монгол Улстай дипломат харилцаа тогтоох эрмэлзэл, эрх зүйн үндэс, улс төрийн орчин ийнхүү эрс өөрчлөгдөж, эдүгээ бид 140 улстай дипломат харилцаа тогтоогоод байна.

Монгол-НҮБ-ын хамтын ажиллагааг эргэн харж дүгнэхэд нэгд, НҮБ-ын хүрээн дэх Монгол Улсын оролцоо, үйл ажиллагаа, хоёрт, манай улсын хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд НҮБ, түүний системийн байгууллагуудаас оруулж буй хувь нэмэр гэсэн хоёр чиглэлээр авч үзэх нь зүйтэй гэж бодож байна.

1. НҮБ дахь Монгол Улсын үйл ажиллагаа

Олон улсын хамтын нийгэмлэг Монголыг өөрийн тэгш эрхт түншээ болгосноос хойш НҮБ-ын системийн бусад байгууллага, олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд нэгдэн орох өргөн боломж нээгдсэн юм. Өнгөрсөн хугацаанд Монгол Улс олон улсын засгийн газар хоорондын 33, бүс нутгийн болон бусад 20 шахам байгууллагын бүрэн эрхт гишүүн боллоо. Түүнээс гадна манай төрийн бус олон байгууллага өөр өөрсдийн чиглэлийн олон улсын холбоодын гишүүн болсон. Нэг үгээр хэлбэл, зарим нэг бүс нутгийн интеграцийг эс тооцвол манай улсын гишүүн болоогүй томоохон байгууллага бараг үгүй гэж хэлж болохоор байна.

Монгол Улс мөн олон улсын 140 гаруй гэрээ, конвенцид нэгдэн орсон буюу батламжилсан нь дэлхий ертөнцөд түүний эзэлж буй орон зай, хүлээсэн үүрэг өргөн болсныг гэрчилнэ.

НҮБ нь дэлхийн улс орнуудыг үзэл суртал, хөгжлийн түвшин, том жижгээр нь ялгалгүй тэгш эрх олгодог байгууллагын хувьд Монгол шиг хөгжиж байгаа жижиг орон санаа бодол, дуу хоолойгоо чөлөөтэй илэрхийлж, олон улсын тавцанд өөрийн байр суурийг эзлэх, энх тайван, хөгжил дэвшлийн үйл хэрэгт дэлхийн улс гүрнүүдтэй хамтран ажиллах өргөн бололцоотой чухал үүд хаалга нээгдсэн. Манай улс ийм бололцоог ашиглаж НҮБ-аас явуулж буй үйл ажиллагаанд хэр чинээгээрээ идэвхтэй оролцож ирснийг тэмдэглэхэд таатай байна.

Энэ хугацаанд энх тайван, нийгэм, эдийн засгийн хөгжил, олон улсын эрх зүйн чиглэлээр Монгол Улсын төлөөлөгчдийн гардан санаачилсан 50 гаруй тогтоолыг НҮБ-ын Ерөнхий Ассамблей батлан гаргасан. Эдгээр нь энх тайвныг бэхжүүлэх, зэвсэг хураах, олон улсын хэлэлцээний үндсэн зарчмуудыг тогтоох, бүх нийтийн боловсролыг дэмжих, хөгжилд мэргэжилтэй боловсон хүчний гүйцэтгэх үүрэг, хөдөөгийн эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах, нийгмийн хөгжилд хоршооллын үүрэг ролийг нэмэгдүүлэх, далайд гарцгүй хөгжиж буй орны хүндрэл бэрхшээлийг даван туулах зэрэг асуудалд олон улсын хамтын нийгэмлэгийн анхаарал, хамтын ажиллагааг чиглүүлэх зорилготой байв.

Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хоёр удаагийн тогтоол, Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн 5 гүрний хамтарсан мэдэгдлийн дүнд олон улсын хамтын нийгэмлэг дэмжих болсон нь манай орны хувьд улс төр, стратегийн чухал ололт мөн.

НҮБ дэх Монгол Улсын идэвхтэй оролцоо, хувь нэмрийг бусад гишүүн орон дэмжиж ирсний нэг жишээ нь, манай улсын төлөөлөгч НҮБ-ын Ерөнхий Ассамблейн орлогч даргаар 6 удаа, Зэвсэг хураах, олон улсын аюулгүй байдлын асуудал эрхэлсэн I хороо, Улс төрийн тусгай хороо, Хууль эрхийн асуудал эрхэлсэн VI хороо, Зэвсэг хураах комиссын дарга зэрэг нэр хүндтэй албан тушаалд сонгогдон ажиллаж байлаа. Мөн НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын чуулганы даргаар 1989, 1999 онд тус тус сонгогдож байв.

Монгол Улс НҮБ-ын сонгуульт байгууллагуудад өнгөрсөн хугацаанд ажиллаж хувь нэмрээ оруулж ирсэн бөгөөд одоо Эмэгтэйчүүдийн байдлын асуудал эрхэлсэн комисс, Тогтвортой хөгжлийн комиссын гишүүнээр ажиллаж байна. Цаашид НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөл болон Аюулгүйн Зөвлөлийн байнгын бус гишүүнээр сонгогдох том зорилт тавиад байна.

НҮБ-тай байгуулсан Санамж бичгийн дагуу 1999 оноос НҮБ-ын Энхийг сахиулах хүчний үйл ажиллагаанд оролцох бэлтгэлийг хангаж байна.

1990-ээд онд хүүхэд, хүрээлэгч орчин, хүн ам, хүний эрх, нийгмийн хөгжил, эмэгтэйчүүд, хүнсний аюулгүй байдлын асуудлаар НҮБ-ын ивээл дор зохион байгуулсан олон улсын бага хурлуудад Монгол Улс идэвхтэй оролцож, тэдгээрээс гаргасан шийдвэрүүдийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхийн төлөө чармайн ажиллаж байна. Удахгүй Нью-Йорк хотноо болох Хүүхдийн асуудлаархи НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 27 дугаар тусгай болон ээлжит 56 дугаар чуулганд Ерөнхий сайд Н.Энхбаяр

тэргүүтэй төлөөлөгчид оролцож, дэлхийн хамгийн нэр хүндтэй энэхүү индэр дээрээс Монгол-НҮБ-ын хамтын ажиллагааны 40 жилийн үр дүн, цаашдын зорилт, Мянганы Тунхаглалыг хэрхэн хэрэгжүүлэх талаар санал бодлоо хуваалцах гэж байгаа нь чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Өнгөрсөн оны Мянганы дээд хэмжээний уулзалтаас баталсан «Мянганы Тунхаглал»-д дэвшүүлсэн томоохон зорилтуудыг хэрэгжүүлэхийн төлөө Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгтэй хамтран зүтгэх шийдвэр төгс байна. Чухам үүнд мөн та бидний хамтран зохиож буй өнөөдрийн бага хурлын үйл ажиллагаа чиглэж байгаа билээ. НҮБ-ын Мянганы Дээд хэмжээний чуулга уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгч Н. Багабанди оролцсон нь Монгол Улс НҮБ-ын үйл хэрэгт өндөр ач холбогдол өгдгийн тод жишээ болсон.

2. Монгол Улсын хөгжилд НҮБ-аас оруулж буй хувь нэмэр

Өнгөрсөн 40 жилийн хугацаанд Монгол-НҮБ-ын хамтын ажиллагаа цар хүрээ, хэлбэр агуулгын хувьд байнга өргөжин тэлж ирлээ. Монголын ард түмний хөгжлийн хүч чармайлтад НҮБ-ын тусламж, дэмжлэг ихээхэн тус нэмэр болсныг онцлон тэмдэглэмээр байна. Эдийн засгийн тусалцаа авч эхэлсэн 1963 оноос хойш НҮБ-аас манай улсад 140 гаруй сая долларын буцалтгүй тусламж үзүүлсний дээр тоогоор үнэлж баршгүй мэдлэг, мэдээллийн ихээхэн потенциалыг Монголд бий болгож өгсөн юм. Энэ нь Монгол Улсаас НҮБ-д төлсөн татвар, хандиваас даруй 20 гаруй дахин их хөрөнгө билээ.

Ная, ерээд оны зааг дээр социалист систем, түүний дотор ЭЗХТЗ задран унаж, улмаар Монголд үзүүлж байсан тусламж, татаас зогссон нь тэртээ тэргүй шилжилтийн хямралд ороод байсан Монголын эдийн засагт хүнд цохилт болсон. Тэр хүнд үед НҮБ, түүний системийн байгууллагууд, ялангуяа Хөгжлийн Хөтөлбөр Монголыг дэмжигч хандивлагчдын бүлгийг үүсгэн бүрэлдүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэсэн нь манай улс орныг гүнзгий хямралаас аварч, тогтвортой хөгжлийн замд оруулах чухал хүчин зүйлийн эхлэлийг тавьсан.

Эдийн засаг, улс төрийн өөрчлөлт шинэчлэлтийг нэгэн зэрэг хийж эхэлсэн Монгол Улсын зориг эрмэлзлийг НҮБ, түүний системийн байгууллагууд халуунаар дэмжин, тусламжийн хэмжээг нэмэгдүүлсэн. Тухайлбал, тусламжийн 1997-2001 оны давтамжид зөвхөн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүн амын сан, Хүүхдийн сан нийтдээ 36 сая орчим долларын төсөл Монголд хэрэгжүүлж байна.

НҮБ бусад хандивлагчдын хамт бидэнд тусламж дэмжлэг үзүүлж ирсэн нэг чухал салбар бол ядуурлыг бууруулах асуудал юм. Монголд гурван хүн тутмын нэг нь ядууралд өртөөд буй өнөө үед эдийн засгийн өсөлтийг хангах стратегитай ядуурлыг бууруулах хүч чармайлтыг эс уялдуулваас ядуурлыг дорвитойгоор бууруулах боломжгүй болохыг бидний өмнөх жилүүдийн туршлага харууллаа. Үүнд манай Засгийн газраас дүн шинжилгээ хийж, ядуурлыг зөвхөн орлогын ядуурал бус түүнээс өргөн хүрээтэй үзэгдэл хэмээн ойлгож, хүний хүчин зүйл, чадавхийг дэмжин хөгжүүлэх, нийгмийн суурь үйлчилгээг хүн амд жигд

хүртээмжтэй хүргэх, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бүтцийг оновчтой зохион байгуулахад анхаарч байна. Мянганы Тунхаглалд «Өдөрт нэг доллараас бага орлоготой хүмүүсийн тоог 2015 он гэхэд тал хувиар багасгах»-аар тавьсан зорилтыг манай улс ойрын 10 жилд багтаан хэрэгжүүлэх бодлого дэвшүүлж, «Эрхийн амьжиргааны чадавхийг сайжруулах» хөтөлбөр боловсруулан ажиллаж байна.

НҮБ-д элссэний 40 жилийн ойн хүрээнд Монгол Улсын Засгийн газар - НҮБ, түүний системийн байгууллагуудтай харилцаж ирсэн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, цаашдын хамтын ажиллагааны чиглэл, төлвийг тодорхойлох зорилт бид тавин ажиллаж байна. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд миний бие Гадаад хэргийн сайдын хувьд Вена, Женев дэх НҮБ-ын зарим байгууллага болон Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын удирдлагатай уулзаж, хамтын ажиллагааны ойрын ирээдүйн чиглэлээр тодорхой тохиролцоонд хүрэв.

Үүнд:

- эрчим хүчний салбарт хамтран ажиллах орны хөтөлбөр байгуулах асуудлаар Олон улсын атомын энергийн агентлагтай,
- үндэсний чадавхийг дээшлүүлэх асуудлаар Цөмийн туршилтыг бүрэн хориглох гэрээний байгууллагатай,
- гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний зөвлөлийн чадавхийг сайжруулах асуудлаар Мансууруулах бодистой тэмцэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх НҮБ-ын албатай,
- манай улсын үндэсний үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хувийн хэвшлийг дэмжих, ялангуяа жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, хүрээлэгч орчинд таатай технологи, үйлдвэрлэл нэвтрүүлэх чиглэлээр хамтын ажиллагааны хөтөлбөр тохиролцох талаар НҮБ-ын Үйлдвэр хөгжлийн байгууллагатай,
- Монголд шинэхэн байгуулагдсан Хүний эрхийн үндэсний комиссыг бэхжүүлж чадваржуулах, хүний эрхийн үндэсний хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх, урьдчилан хорих байгууллагын нөхцлийг сайжруулах зэрэг чиглэлээр хамтын ажиллагааг идэвхжүүлэх талаар тохирч, эдгээр асуудлыг тусгасан Хамтарсан мэдэгдэлд НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссар хатагтай М.Робинсонтой гарын үсэг зурав.

Түүнчлэн,

- хөдөөд холбоо, мэдээллийн төв байгуулах, зайн сургалт, теле-эмчилгээ гэх мэт мэдээллийн технологи нэвтрүүлэх туршилтын төслүүд хэрэгжүүлэх асуудлаар Олон улсын цахилгаан холбооны байгууллагатай,
- Монгол Улсаас оюуны өмчийн салбарт нэгдэн орсон олон улсын гэрээ конвенциудыг хэрэгжүүлэх, үндэсний сургалтын төв байгуулах зэрэг чиглэлээр 2002-2006 онд хамтран ажиллах орны хөтөлбөр байгуулахаар Дэлхийн оюуны өмчийн байгууллагатай,
- байгаль орчныг нөхөн сэргээх, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, агаарын бохирдолд тавих хяналтыг бэхжүүлэх, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, учирсан хохирлыг арилгах зэрэг чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар Дэлхийн цаг уурын байгууллагатай,

- дамжин өнгөрөх тээврийг хөнгөвчлөх эрх зүйн орчин бүрдүүлэх зэрэг асуудлаар НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын удирдлагатай санал солилцож тохиролцсон нь дээрх чухал салбарт хамтын ажиллагааг ойрын ирээдүйд хэрхэн хөгжүүлэх тодорхой чиглэлийг тодорхойлсноороо чухал ач холбогдолтой болов.

Зэвсэг хураах бага хурлын ажлыг сэргээн эрчимжүүлэх шаардлага тавигдаж буй өнөө үед зэвсэг хураах асуудлаар хэлэлцээ явуулдаг олон талт цорын ганц механизм болох энэхүү нэр хүндтэй байгууллагад Монгол Улсын Гадаад хэргийн сайдын хэмжээнд өнгөрсөн 5 дугаар сард анх удаа оролцож үг хэлсэн нь ач холбогдолтой болсон гэж үзнэ.

Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисстой мөн далайд гарцгүй хөгжиж буй орнуудын асуудал, Зүүн Хойд Азийн бүс нутаг дахь дэд бүтцийн хөгжил, хот суурин газар болон хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах, ядуурлыг бууруулах, шинээр гарч ирж буй нийгмийн асуудал, тухайлбал хүүхэд, эмэгтэйчүүдийг дамлан худалдаалах, хүүхдийг биеэ үнэлэхэд уруу татан оролцуулах, ДОХ-ын тархалт, хөдөлмөрийн шилжих хөдөлгөөн зэрэг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар хамтран ажиллахаар тохиролцоод байна.

Энэ мэтчилэн, Монгол-НҮБ-ын хамтын ажиллагааны хэрэгжүүлж буй болон тохиролцсон арга хэмжээний талаар олон жишээ баримт дурдаж болно. Харин Монгол-НҮБ-ын хамтын ажиллагааг 40 жилийн өндөрлөгөөс бүхэлд нь эргэн дүгнэхэд бүх зүйл тийм ч дардан, өө сэвгүй байсан гэж хэлж боломгүй байна. Манай улс НҮБ, түүний системийн байгууллагуудын өмнө хүлээсэн үүргээ тэр бүр бүрэн биелүүлж чадахгүй байсныг цэгнэн хэлэлцэх учиртай. Үүнд юуны өмнө татвар хандивын асуудал хамаарна. Хэдийгээр бид шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээлээс үүдэн хөрөнгө мөнгөний хомсдолтой байнга тулгарч байгаа хэдий ч олон улсын байгууллагуудын өмнө хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлж байхад хойшид анхаарах шаардлагатай гэж үзнэ.

Үүний зэрэгцээ бид олон улсын конвенцийн дагуу хүлээсэн үүрэг, олон улсын хурлаас авсан амлалтаа үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх талаар сайжруулах зүйл нэлээд бий гэж бодогдож байна. Дотоодын нөөц бололцоогоо сайтар дайчлан дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэх нь Та бидний хамгийн ойрын ирээдүйн зорилт болж байна.

Мөн НҮБ-ын системийн байгууллагуудаас манай улсад үзүүлж байгаа тусламж, дэмжлэгийн үр өгөөж, зохицуулалтыг цаашид сайжруулж боловсронгуй болгох нь Монгол-НҮБ-ын хамтын ажиллагааг амжилттай урагшлуулахад туйлын ач холбогдолтой гэдгийг энд дурсахгүй өнгөрч боломгүй.

Хатагтай, ноёд оо,

Одоо цаашдын хамтын ажиллагааг бид хэрхэн төсөөлж байгаа талаар санал бодлоо хуваалцахыг зөвшөөрнө үү.

3. Цаашдын зорилтууд

Монгол Улсын Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр болон түүнд тодорхойлсон тэргүүлэх чиглэлийн зорилтууд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Мянганы илтгэлд дэвшүүлсэн үндсэн зорилтуудтай нийцэж байгаа нь Монгол-НҮБ-ын хамтын ажиллагааг цаашид улам үр ашигтай болгох өргөн боломж олгож байна. Иймээс ч манай Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтуудыг амжилттай хэрэгжүүлэхэд НҮБ, түүний системийн байгууллагуудын үүрэг, хувь нэмэр онцгой ач холбогдолтой байх юм. Гэхдээ бид энэхүү хамтын ажиллагааг шинэ агуулга хэлбэрээр баяжуулж, арга барилаа боловсронгуй болгоход анхаарч ажиллах нь чухал.

- Юуны өмнө, бид НҮБ-аас авч буй тусламжийг Монгол Улсын хөгжил дэвшлийн тэргүүлэх салбар, чиглэлүүдэд төвлөрүүлж, үр ашгийг нь улам дээшлүүлэх шаардлага тулгарч байна. Энд, өндөр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, Монгол орны онцлогт таарсан судалгаа шинжилгээ хийх, гадаадын шинэ техник, технологи нэвтрүүлэх, хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах, тухайлбал мэдээлэл, холбооны технологи нэвтрүүлэх замаар нийгэм, соёл, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг малчдад хүргэх зэргийг дурдаж болох юм.

- Мөн байгалийн гамшиг, тухайлбал зуд турхан, ган гачигтай тэмцэх, гамшгийн далайцыг урьдчилан тооцоолж, бэлэн байх үндэсний чадавхи, менежментийг сайжруулах явдал туйлын чухал болоод байна. Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд, Мянганы илтгэлд дэвшүүлсэн хөгжиж байгаа орнуудад зориулан эрүүл мэндийн чиглэлийн мэдээлэл түгээх 10 мянган цэг бүхий сүлжээ байгуулах, байгалийн гамшигт нэрвэгдсэн бүс нутгийг мэдээллийн найдвартай холбоогоор хангах саналуудыг ажил хэрэг болгох талаар бид НҮБ-тай хамтран ажиллах саналтай байна. Энэ нь хүн ам нэн сийрэг, дэд бүтэц сул хөгжсөн, байгалийн гамшигт олонтаа өртдөг Монгол орны хувьд чухал ач холбогдолтой гэж үзнэ.

- Хүний аюулгүй байдлыг бүрэн хангах, тухайлбал, амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, хоол хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулахад НҮБ чухал үүрэг гүйцэтгэж чадна. Бид энэ чиглэлээр «Хүний аюулгүй байдлын төлөө сайн засаглал» хөтөлбөрийг боловсруулж, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж эхлээд байгаа нь үүний чухал эхлэл юм.

- Хүний хөгжлийн асуудалд боловсрол туйлын чухал үүрэг гүйцэтгэдгийг харгалзан энэ чиглэлээр бид НҮБ-тай илүү идэвхтэй хамтран ажиллахыг зорьж байна, тухайлбал бүх нийтэд насан туршийн боловсрол мэдлэг олгоход чиглэсэн улс төрийн хүсэл эрмэлзлийг дайчилж, тавьсан зорилтоо хэрэгжүүлэх үүднээс НҮБ-аас бичигтэн болох олон улсын 10 жил зарлах нь зүйтэй гэж үзэж байна.

- Дэлхийн улс орнуудын хооронд төдийгүй нэг улс доторхи хөгжлийн түвшний ялгаа ихээхэн нэмэгдэж байгааг манай Засгийн газар бүрнээ ойлгож, «аймаг, орон нутаг зах зээлийн харилцаанд жинхэнэ утгаараа шилжиж чадаагүй, хөгжлийн түвшнээр илт хоцронгуй байдалтай болсон»-д дүгнэлт хийн, уг асуудлыг иж бүрэн шийдвэрлэх зорилго бүхий «Монгол

Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал» боловсруулж, УИХ-аар батлуулсан билээ.

Энэхүү бодлогыг хэрэгжүүлэх нь олон улсын хамтын нийгэмлэгийн өмнөө тавьж буй «хөгжлийн ялгааг багасгах» глобал зорилттой нийцэж байгаа учир НҮБ болон түүний системийн байгууллагуудтай хамтран ажиллах манай цаашдын үйл ажиллагааны нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болох ёстой гэж бодож байна.

- Эдийн засгийн хувьд жижиг болон эмзэг орнуудын онцлог эрх ашгийг урагшлуулах талаар бид НҮБ-тай хамтран идэвхтэй ажиллах бодолтой байна. Энэ нь ялангуяа даяаршлын үйл явц гүнзгийрэн эрчимжиж буй өнөө үед түүний үр шимийг жижиг, эмзэг эдийн засагтай орнууд, ялангуяа газар зүйн таагүй байршилтай, хөгжлийн хүч чармайлтад нь өвөрмөц хүндрэл, бэрхшээл учирч буй улс орнуудад хүртээмжтэй болгох асуудалд олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс түлхүү анхаарч, дэмжлэг тусалцаа үзүүлэх ёстой гэж бид үзэж байна. Тийм ч учраас Монгол улс Жижиг улсуудын аюулгүй байдлын эрх ашгийг хамгаалахад НҮБ-ын үүрэг ролийг хэрхэн нэмэгдүүлэх талаар Засгийн газрын байр сууриа илэрхийлсэн Санамж бичгийг НҮБ-ын албан ёсны баримт бичиг болгон Мянганы чуулганд тараасан билээ.

Ноёд, хатагтай нар аа,

Хүн бүрийн тэгш эрх, идэвхтэй оролцоо, эрх чөлөөг хангасан иргэний нийгэм байгуулах бидний зорилгыг хэрэгжүүлэхэд НҮБ урьдын адил үр өгөөжтэй хамтран ажиллана гэдэгт эргэлзэхгүй байна.

НҮБ болон Монгол Улс аль аль нь өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа энэ үед хоёр тал илүү идэвхтэй хамтран ажиллах таатай нөхцөл, уур амьсгал бүрэлдсэн гэж бодож байна. Манай Засгийн газар НҮБ-тай хамтран ажиллах, түүний тусламжийн үр ашгийг улам өгөөжтэй болгох асуудалд иж бүрэн хандаж, нэмэлт эх үүсвэр, ашиглалтын шинэ арга хэлбэрийг эрэлхийлэн ажиллах болно.

Өнөөдрийн энэхүү бага хуралд өөрийн зарим санал бодлоо толилуулахад ийм байна. Та бүхэн ажил хэрэгч, үнэтэй санал бодлоо бидэнтэй хуваалцаж идэвхтэй оролцоно гэж найдаж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.